



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 4/09

Модот

Ажлын хэсэг томилох тухай
(Сумын төвийн шороон замын засвар)

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн, 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, 50 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа Сумын төвийн шороон замын засвар, хотгор гуу жалга тэгшлэх, тэмдэг тэмдэглэгээ хийх, зам арчлалтын ажлын худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч О.Тунгалагмөрөн – 4 дүгээр багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга Ж.Тодбилэг – Байгаль хамгаалагч

Гишүүд Э.Тулгаа - Цэнхэрмандал хөгжил ТӨҮГ дарга


С.Энхбаяр - Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Д.Өсөхгэрэл - Мал үржүүлэг, технологийн ажил

үйлчилгээний хяналтын улсын байцаагч

2. Дээрх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, байгуулсан гэрээний дагуу гэрээг дүгнэх, хүлээн авах акт үйлдэх, гүйцэтгэлийн тайланг гүйцэтгэгчээс гаргуулж авахыг ажлын хэсгийн ахлагч (О.Тунгалагмөрөн) –д үүрэг болгосугай.

ДАРГА



Ү.ИЧИНХОРЛОО